

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ТАЙЛАГНАЛ БОЛОН БЭЛТГЭСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт

АУДИТЫН КОД:

ҮАГ-НАГ/2020/05-НА-ХЭ

Чингис хот. 2020 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112. Цахим хаяг:
erdenebaatarch@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа
Утас: 92116773 Цахим хаяг:
oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Туяа
Утас: 92116760 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn
Аудитор Г.Энх-Амгалан
Утас: 91119424 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас:
www.audit.mn

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
НА	Нийцлийн аудит
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ЗГБХН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
АМХБАТЗ	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл

АГУУЛГА		
<p>Тайлан бэлтгэсэн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа</p> <p>Ахлах аудитор: Н.Туяа Аудитор Г.Энх-Амгалан</p> <p>2020 оны 11 дүгээр сар</p> <p>Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймаг дахь Төрийн Аудитын газрын khentii@audit.gov.mn, 70562112 факсаар харилцана уу.</p> <p>Хаяг: Хэнтий аймаг Чингис хот АЗДТГ-ын байр. 320 тоот өрөө</p>	Ерөнхий зүйл	
	Аудит хийсэн үндэслэл	3
	Аудитын зорилт , хамарсан хүрээ	3
	Үндсэн мэдээлэл	3
	Арга зүй	4
	Шалгуур үзүүлэлт	4
	БҮЛЭГ 1: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ БҮРДҮҮЛЭЭГҮЙ, ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТЛАГДСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.	5-8
	1.1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг батлахдаа Төсвийн тухай хуульд нийцээгүй эх үүсвэрийг оруулан төлөвлөж баталсан байна.	5
	1.2. ОНХС-аас 222.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу төвлөрүүлсэн байна.	5
	1.3. Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилаагүй байна.	6
БҮЛЭГ 2: ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС БЭЛТГЭСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	9-16	
2.1 Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд баримтлах зарчмыг бүрэн мөрдөж ажиллах шаардлагатай байна	9	
2.2 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна .	12	
БҮЛЭГ 3: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВЬДАГГҮЙ, ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.	17-19	
3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймаг, сумын ЗДТГ-ууд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна	17	
3.2. Аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох журам, зааврын дагуу Сангийн яаманд хүргүүлээгүй, нэгдсэн мэдээ тайланг гаргаагүй байна.	16	
3.3. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 71.8 хувьтай байна.	17	
Дөрөв. Дүгнэлт	20	
Тав. Аудитын зөвлөмж	20	
Зургаа. Холбогдох байгууллагын санал	21	
Долоо. Тэргүүлэх аудиторын тушаал	22	
Судалгаа /маягт 1.2.4.5.6.7.8 /		

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**Аудит хийсэн үндэслэл**

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг ҮАГ-т тайлагнаж, аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2019 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, тайлагналыг аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, баг хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгалаа.

Үндсэн мэдээлэл

Төсвийн тухай хуульд “**Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ**” гэж заасан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаартай “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” тогтоолын дагуу олгож байна.

Мөн орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулж байна.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох дэмжлэгийн хэмжээг 5,052.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн ОНХС-д 95.2 хувийн гүйцэтгэлтэй хуваарилсан байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг

№	Аймгийн нэр	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгийн дүн /сая.төг/	Тогтвортой амьжиргаа -3 төслөөс / сая төг/		Нийт эх үүсвэр /сая.төг/
			Дэмжлэг	Урамшуулал	
1	Хэнтий	4,156.1	459.5	214.6	4,830.20

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, үр дүнтэй гүйцэтгэлд нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 04 дүгээр хавсралтаар Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу дээрх төслөөс 18 сумдын ОНХС-д 459.5 сая төгрөгийн дэмжлэг, 15 сумдын ОНХС-д 214.6 сая төгрөгийн урамшуулал, нийт 674.1 сая төгрөгийг олгосон байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2019 онд ОНХС-аас санхүүжих нийт 5,070.6 сая төгрөгийн 196 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ аймаг, сумын ИТХ-аар батлагдсанаас 37.4 сая төгрөгийн 6 хөтөлбөр төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос хэрэгжиж эхэлсэн байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2019 онд нийт 196 төсөл, арга хэмжээний 6 нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж, 5,033.2 сая төгрөгийн 190 арга хэмжээнээс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1,132.7 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг, харьцуулалтын аргаар 2,466.6 сая төгрөгийн 81 төсөл арга хэмжээг, шууд худалдан авалтын аргаар 460.5 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээг, 130.5 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж, 749.4 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээний худалдан авалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100-400, 4000 дугаар стандартууд, Төрийн аудитын тулгуур зарчим MNS6817:2020, Нийцлийн аудитын зарчим MNS6817-6:2020, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, аймаг, сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, иргэдээс санал асуулга авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 9 сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

БҮЛЭГ 1. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЭЭГҮЙ, БАТЛАГДСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

1.1 АЙМГИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ БҮРДҮҮЛЭЭГҮЙ, СУМЫН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТАЛСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

1.1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг батлахдаа Төсвийн тухай хуульд нийцээгүй эх үүсвэрийг оруулан төлөвлөж баталсан байна.

1. Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг “Төсвийн тухай” хуулийн 60.2-т заасан эх үүсвэрийн дагуу 5,052.7 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

- ❖ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 3,938.0 сая төгрөг
- ❖ Улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг АМХБАТЗ-ийн 50 хувь 440.6 сая төгрөг
- ❖ Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал 214.6 сая төгрөг, дэмжлэгт 459.5 сая төгрөг

2. Аймаг, сумдын ИТХ-аар ОНХС-ийн эхний үлдэгдэл болон өмнөх оны төсвийн үлдэгдлээр нэмэгдүүлэн тодотгож, 2019 онд ОНХС-ийн эх үүсвэрт нийт 5.677.7 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж баталсан байна.

- ❖ Орон нутгийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 3,938.0 сая төгрөг
- ❖ Улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг АМХБАТЗ-ийн 50 хувь 440.6 сая төгрөг
- ❖ Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал 214.6 сая төгрөг, дэмжлэгт 459.5 сая төгрөг
- ❖ Аймагийн төсвийн орлогын эх үүсвэрээс
 - Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар аймагийн ОНХС-д 120.0 сая төгрөг,
 - Аймагийн ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс 48.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна
- ❖ Сумдын орлогын эх үүсвэрээс:
 - Сумдын ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс 145.2 сая төгрөг,
 - Сумын өмнөх оны татварын орлогын давсан үлдэгдлээс 311.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор сумын өмнөх оны татварын орлогын давсан үлдэгдлээс 311.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд эх үүсвэр болгон олгохоор баталсан нь Төсвийн тухай хуулийн 60.2¹ дахь заалтад нийцээгүй байна. Үүнд:

Өмнөдэлгэр сум 105.3 сая төгрөг, Бор-Өндөр сум 71.1 сая төгрөг, Дэлгэрхаан сум 50.0 сая төгрөг, Дадал сум 41.3 сая төгрөг, Цэнхэрмандал сум 35.6 сая төгрөг, Батширээт сум 7.8 сая төгрөг

Дээрх зөрчлийг 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлж, зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлагыг холбогдох сумын Засаг дарга нарт хүргүүлсэн байна.

1.2. ОНХНС-аас 222.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу төвлөрүүлсэн байна.

ОНХНС-аас Хэнтий аймагийн ОНХС-д АМХБАТЗ-ийн төлбөрийн 50 хувийн орлого болон орлогын шилжүүлэгт 4,156.1 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс дэмжлэг, урамшуулалд 674.1 сая төгрөг олгожээ.

ОНХС-ийн 2018 оны үлдэгдлээс 193.7 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар 120.0 сая төгрөг, сумын өмнөх оны давсан татварын орлогын үлдэгдлээс 311.1 сая төгрөг, хандив тусламжаар 0.1 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 1.8 сая төгрөгийг, нийт 5,456.9 сая төгрөгийг аймаг, сумын ОНХС-ийн өөрийн орлогын эх үүсвэрийг

¹ 60.2. “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:...”

бүрдүүлсэн байна. Бусад эх үүсвэрт Хэрлэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд барьж, иргэдэд худалдсан хашааны үнэ 1.8 сая төгрөг төвлөрсөн байна. Хүснэгтээр харуулбал:

ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ /сая төг/

№	Эх үүсвэр	Төсвийн тухай хуулийн заалт	Батлагдсан дүн	Төвлөрсөн дүн	Зөрүү
1	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	60.2.1, 60.2.2	3937.9	3715.5	222.4
2	АМХБАТЗ-ийн төлбөрийн орлогын 50%	60.2.7	440.6	440.6	0
3	Тогтвортой амьжиргаа -3 төслийн дэмжлэг, урамшуулал	60.2.5	674.1	674.1	0
4	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон эх үүсвэр	60.2.4	120.0	120.0	0
5	Аймаг, сумын ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс		193.8	193.7	0.1
6	Хандив тусламж, бусад	60.2.5		1.9	-1.9
7	Сумын өмнөх оны орлогын давсан үлдэгдлээс		311.3	311.1	0.2
	Дүн		5677.7	5456.9	220.8

- Аймгийн ОНХС-д ОНХНС-аас олгохоор батлагдсан орлогын шилжүүлгийг Сангийн яамнаас 222.4 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.
- Мөн аймаг, сумын ОНХС-д оны эхэнд 345.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад аймаг, сумын ИТХ-аас 193.8 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Аймаг, сумын ОНХС-д 2018 оны эцэст нийт 345.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2019 оны эцэст 726.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

1.3. Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор нийт зарлагыг 5,221.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгийг ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 2,365.7 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрээс 120.0 сая төгрөгөөр тооцож 2,485.7 сая төгрөг,
- Сумдад олгох орлогын шилжүүлгийг 1,013.8 сая төгрөгөөр, Тогтвортой амьжиргаа-3 төслийн 459.5 сая төгрөгийн дэмжлэг, 214.6 сая төгрөгийн урамшуулал, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувь болох 440.6 сая төгрөгийг нэмж 2,128.5 сая төгрөг,
- Сангийн яамнаас хуваарилсан орон нутгийн суурь зарлага 558.4 сая төгрөг дээр ОНХС-ийн эхний үлдэгдлээс 48.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 607.0 сая төгрөг /Хот тохижилтын зардалд 37.1 сая төгрөг, усны татаас хөнгөлөлтөд 11.5 сая төгрөг/ нэмж тодотгон баталжээ.

1. Аймгийн ИТХ-аар Сангийн яамнаас хуваарилсан орон нутгийн суурь зарлага 558.4 сая төгрөг дээр ОНХС-ийн эхний үлдэгдлээс 48.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.9² дэх заалтыг зөрчсөн байна.

² “ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх суурь зардлыг тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хэмжээнээс хэтрүүлэхгүй”

Хэнтий аймагт орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилагдсан 5052.7 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс ОНХС-аас санхүүжих суурь зарлага 558.4 сая *төгрөг / үүнд: мал эмнэлгийн үйлчилгээ 388.6 сая төгрөг, Хот тохижилтын зардал 169.8 сая төгрөг/* болон Тогтвортой амьжиргаа-3 төслийн 459.5 сая төгрөгийн дэмжлэг, 214.6 сая төгрөгийн урамшуулал, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувь болох 440.6 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус хасаж, үлдэх 3,379.5 сая төгрөгийг хуваарилсан байна.

“Төсвийн тухай” хуулийн 59.2.2³ заалтын дагуу 3,379.5 сая төгрөгийг 30:70 хувь хэмжээгээр тооцож 70 хувь буюу 2,365.7 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 30 хувь буюу 1,013.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8.3⁴ заалтын дагуу сумдад хуваарилсан боловч дараах алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

2. Орон нутгийн суурь үзүүлэлтэд үндэслэж хуваарилалт хийхдээ аймгийн нийт газар нутгийн хэмжээнд тосгодын газар нутгийн хэмжээг оруулаагүй тооцсоноос итгэлцүүрээр сумдад олгох шилжүүлгийн дүн зөрүүтэй тооцогдсон байна. Хүснэгтээр харуулбал:

Алслалт, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан хуваарилсан нь

/мянган төгрөг/

№	Сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Сумдын ОНХС-д итгэлцүүрээр хуваарилах суурь дүн			Төрийн сангийн тооцоолол	Аудитаар тооцсон дүн	
			Алслалтаас хамаарах хуваарилалт 30%	Хүн амын тооноос хамаарах хуваарилалт 40%	Нутаг дэвсгэрээс хамаарах хуваарилалт 30%		Итгэлцүүрээр хуваарилсан суурь дүн	Аудитаар тооцсон дүн
1	Галшар	667.6	11,698.0	11,976.6	26,568.5	50,243.0	48,956.0	1,287.05
2	Баянхутаг	602.9	2,035.2	12,691.4	23,995.1	38,721.7	37,557.0	1,164.66
3	Баянмөнх	255.4	6,505.6	8,925.1	10,163.4	25,594.1	25,103.0	491.09
4	Дархан	431.1	11,040.1	10,445.5	17,155.6	38,641.1	37,811.0	830.11
5	Дэлгэрхаан	262.7	12,215.0	13,406.3	10,454.6	36,075.8	40,716.0	(4,640.19)
6	Жаргалт хаан	275.1	8,461.5	11,608.5	10,948.0	31,018.0	30,488.0	530.02
7	Цэнхэрмандал	317.7	11,192.3	10,589.5	12,642.5	34,424.3	33,813.0	611.33
8	Өмнөдэлгэр	979.9	26,373.9	30,152.1	38,996.6	95,522.6	97,717.0	(2,194.38)
9	Батширээт	701.8	17,834.6	12,483.4	27,928.7	58,246.6	56,894.0	1,352.62
10	Биндэр	536.6	28,712.9	21,408.4	21,354.9	71,476.2	70,443.0	1,033.22
11	Баян-Адарга	302.1	15,626.5	13,315.6	12,022.9	40,965.0	40,383.0	581.99
12	Дадал	472.7	31,560.5	16,036.3	18,812.9	66,409.7	65,499.0	910.68
13	Норовлин	533.4	19,287.3	13,230.2	21,225.5	53,743.0	52,717.0	1,026.05
14	Батноров	494.3	22,505.5	29,405.2	19,671.4	71,582.2	70,725.0	857.19
15	Баян-Овоо	338.1	9,339.0	9,490.5	13,457.1	32,286.6	31,633.0	653.63
16	Бор-Өндөр	14.4	67,759.2	47,671.5	573.1	116,003.8	115,981.0	22.77
17	Мөрөн	219.6	2,010.6	10,216.1	8,739.2	20,965.9	20,543.0	422.87
18	Хэрлэн	237.4	-	122,491.6	9,447.7	131,939.3	136,880.0	(4,940.73)
	Сумын дүн	7642.8	304,157.7	405,543.6	304,157.7	1,013,859.0	1,013,859.0	

³ 59.2.2. энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

⁴ 8.3. Аймаг нийслэл нь энэ аргачлалын 8.2-т заасны дагуу хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг дараах байдлаар тооцно:

8.3.1. Хүн амын тооноос хамаарах – 40%

8.3.2. Алслалтаас хамаарах – 30%

8.3.3. нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах – 30%

Нутаг дэвсгэрийн хэмжээг буруу тооцоноос Дэлгэрхаан суманд 4.6 сая төгрөг, Өмнөдэлгэр суманд 2.2 сая төгрөг, Хэрлэн суманд 5.0 сая төгрөгийг тус тус дутуу, Батширээт суманд 1.4 сая төгрөг, Галшар суманд 1.3 сая төгрөг, Баянхутаг суманд 1.2 сая төгрөг, Биндэр, Норовлин суманд тус тус 1.0 сая төгрөг, бусад суманд 0.9-0.4 сая төгрөгийг илүү тооцож, хуваарилсан байна.

3. Мөн сумдад олговол зохих орлогын шилжүүлгээс бусад сумдад олгосон байна. Үүнд Батноров, Бор-Өндөр сумын дүнг тус тус 10.0 сая төгрөгөөр бууруулан, Мөрөн суманд 20.0 сая төгрөгийг нэмж олгохоор өөрчилж ИТХ-аар батлуулсан байна. Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 59.2.2⁵ дахь заалтад нийцээгүй байна.

СУМЫН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ ТООЦСОН НЬ

Сумдын нэр	сая төгрөг												
	59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;				Итгэлцүүрээр хуваарилсан дүн	АМХБАТЗТ 50%	Тогтвортой амьжиргаа 3 төсөл		ОНХС-д хуваарилагдах нийт дүн	АИТХ-аар баталсан дүн			Аудитаар
	Алслалтаас хамаарах %	Хүн амын тооноос хамаарах	Нутаг дэвсгэрээс хамаарах	Дэмжлэг			Урамшуулал	Сум		Тосгон	АИТХ 2019/05/17	Зөрүү	
Галшар	11.7	12.0	25.3	48.9	11.5	22.8	13.5	96.78	98.1		98.1	1.29	
Баянхутаг	2.0	12.7	22.8	37.6	26.9	17.5	0.0	82.0	83.2		83.2	1.16	
Баянмөнх	6.5	8.9	9.7	25.1	25.1	11.6	7.8	69.6	70.1		70.1	0.49	
Дархан	11.0	10.4	16.3	37.8	34.1	17.5	11.4	100.8	101.6		101.6	0.83	
Дэлгэрхаан	12.2	13.4	15.1	40.7	17.7	16.4	10.1	84.9	60.3	20.0	80.3	(4.64)	
Жаргалтхаан	8.5	11.6	10.4	30.5	16.1	14.1	9.3	70.0	70.5		70.5	0.53	
Цэнхэрмандал	11.2	10.6	12.0	33.8	39.0	15.6	10.0	98.4	99.0		99.0	0.61	
Өмнөдэлгэр	26.4	30.2	41.2	97.7	4.8	43.3	24.5	170.3	108.1	60.0	168.1	(2.19)	
Батширээт	17.8	12.5	26.6	56.9	7.9	26.4	16.0	107.2	108.6		108.6	1.35	
Биндэр	28.7	21.4	20.3	70.4	12.5	32.4	0.0	115.4	116.4		116.4	1.03	
Баян-Адарга	15.6	13.3	11.4	40.4	12.7	18.6	12.0	83.7	84.3		84.3	0.58	
Дадал	31.6	16.0	17.9	65.5		30.1	19.5	115.1	116.1		116.1	0.91	
Норовлин	19.3	13.2	20.2	52.7	24.4	24.4	15.8	117.2	118.2		118.2	1.03	
Батноров	22.5	29.4	18.8	70.7	81.6	32.4	13.6	198.4	109.2	80.0	189.2	(9.14)	
Баян-Овоо	9.3	9.5	12.8	31.6	33.5	14.6	9.5	89.2	89.9		89.9	0.65	
Бор-Өндөр	67.8	47.7	0.5	116.0	4.1	52.6	35.1	207.7	197.8		197.8	(9.98)	
Мөрөн	2.0	10.2	8.3	20.5	14.1	9.5	6.3	50.5	70.9		70.9	20.42	
Хэрлэн	0.0	122.5	14.4	136.9	74.7	59.8	0.0	271.4	226.4	40.0	266.4	(4.98)	
Сумдын дүн	304.2	405.6	304.2	1,013.9	440.6	459.5	214.6	2,128.6			2128.6		

Дээрх хүснэгтээс үзэхэд сумдад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг холбогдох хууль, журам зааврын хүрээнд хуваарилаагүй байна.

Аудитаар Төсвийн тухай хуулиар батлагдсан суурь зардлыг нэмэгдүүлсэн болон сумдад олгох орлогын шилжүүлгийг холбогдох заавар журмын дагуу хуваарилаагүй зөрчлүүдийг дахин давтахгүй байх 86.3 сая төгрөгийн 1 албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

⁵ 59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС БЭЛТГЭСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1 АЙМАГ, СУМЫН ЗДТГ НЬ ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХӨД БАРИМТЛАХ ЗАРЧМЫГ БҮРЭН МӨРДӨЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1.1. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 25.3 хувь нь холбогдох заавар журамд нийцээгүй байна.

Сумын ОНХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн нийт 166 төсөл, арга хэмжээнээс “Төсвийн тухай” хуулийн 58.4-д заасан сумын төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нийцээгүй 53.5 сая төгрөгийн 7 ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Дэлгэрхаан сумын ЕБС-ийн спорт заалны зураг 9.0 сая төгрөг, Баян-Адрага сум арьс шир элдэх төхөөрөмж 6.4 сая төгрөг, Баянмөнх сум Архидалтгүй Баянмөнх хөтөлбөр 1.5 сая төгрөг, гудамжны хаягжуулалт хийх 5.0 сая төгрөг, Хогны менежментийг сайжруулах 8.9 сая төгрөг, Батноров сум булаг шандын эх хаших 6.0 сая төгрөг, Цэнхэрмандал сум малын үүлдэр угсааг сайжруулах ажил 16.7 сая төгрөг.

Багийн ИНХ-аас санал авч дэмжигдээгүй 100.3 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг ОНХС-аас санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулж сумын ИТХ-аар батлуулсан нь “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.2⁶, 3.1.4⁷, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.5⁸ дахь заалттай нийцээгүй байна. Үүнд:

Баянхутаг сумын ЕБС-ийн тоног төхөөрөмж 3.0 сая төгрөг, нийтийн эзэмшлийн хашаа 25.0 сая төгрөг, багийн төвийн дэд бүтэц 15.0 сая төгрөг, ЕБС-ийн их засвар 27.9 сая төгрөг, ЭМТ-ийн дээврийн засвар 20.0 сая төгрөг, Баянмөнх сумын хөшөө барих 10.0 сая төгрөгийн ажлууд байна.

Аудитын явцад Баянхутаг сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг 2018 оны 10,11 сард багийн иргэдээс авсан боловч багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлээгүй, хүчин төгөлдөр бус баримт үйлдсэн, Норовлин сумын Жаргалант баг, Баян-Адрага сумын Дуурлиг баг, Бэрх тосгон ирц хүрээгүй хурлаар иргэдийн саналыг хэлэлцүүлж тогтоол баталсан, Мөрөн сум багийн иргэдээс санал авсан хуудасны бүртгэлгүй, Хэрлэнбаян-Улаан тосгон багийн ИНХ-д оролцсон иргэний тоо мэдээгүй, Баян-Адрага сум иргэдээс авсан саналыг эрэмбэлэх ажлын хэсэг байгуулаагүй зэрэг нь “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 5.6⁹-5.15 дахь заалтад нийцээгүй байна.

⁶ 3.1.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

⁷ 3.1.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;

⁸ 6.3.5. иргэдийн оролцоог хангасан байх;

⁹ 5.6.Энэ журмын 5.2-т заасан хэлбэрээр иргэдээс санал авах ажлыг жил бүр зохион байгуулна.

5.7.Баг, хорооны Засаг дарга энэ журмын 5.6-д заасны дагуу иргэдээс авсан саналыг нэгтгэн урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ энэ журмын 5 дугаар хавсралтад заасан маягтад багтсан үзүүлэлтийг ирсэн санал бүрийн хувьд боловсруулах ба энэ журмын 5.1-д заасан танилцуулгад үндэслэн мэдээлэл бэлтгэж, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал /цаашид ИНХ гэх/-д оруулж хэлэлцүүлнэ.

5.8. Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

Сумын ОНХС-аас санхүүжих 155.1 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлтэй уялдаагүй нь “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1¹⁰, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.4¹¹ дэх заалттай нийцээгүй байна. Тухайлбал:

Дархан сумын тохижилт 68.4 сая төгрөг, Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны байрны засвар 20.0 сая төгрөг, цэцэрлэгт хүрээлэнгийн гадна тоглоом авах 8.0 сая төгрөг, ЕБС-ийн гал тогоонд ширээ сандал авах 3.5 сая төгрөг, Баянхутаг сумын ЭМТ-ийн дээврийн засвар 20.0 сая төгрөг, Багийн төвийн дэд бүтэц 14.9 сая төгрөг, ЕБС-д техник хэрэгсэл авах 3.0 сая төгрөг, Дархан сумын ЭМТ-д тоног төхөөрөмж авах 10.4 сая төгрөг, Хэрлэнбаян-Улаан тосгоны ан амьтан хамгаалах 5.0 сая төгрөг, эгнээ гудамжны хаягжуулалт хийх 1.9 сая төгрөг

Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэлгүй, ажлын даалгавар нь бэлэн болоогүй 96.9 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг ОНХС-аас санхүүжүүлэх ажлын жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулсан нь “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3 дахь заалттай нийцээгүй байна. Үүнд:

Галшар сум нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах 21.0 сая төгрөгийн, Бор-Өндөр сумын орчин үеийн жишигт нийцсэн мөсөн гулгалтын талбай байгуулах 20.0 сая төгрөгийн, Баян-Адрага сумын 9.9 сая төгрөгийн бэлчээрийн 3 худаг гаргах, Биндэр сумын 3-р багийн төвийн 4.0 сая төгрөгийн тохижилт, Хэрлэн сумын 5 багт эко нойл барих 30.0 сая төгрөгийн ажлууд хэрэгжээгүй байна. Мөн Биндэр сумын 1,2,4-р багийн төвийн тохижилтын ажлууд зураг төсөвгүй батлагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 64.0 сая төгрөгийн 3 арга хэмжээний цаашид гарах урсгал зардал, төсөвт нөлөөлөх нөлөөллийг тооцоогүй нь “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-

5.9. Баг, хорооны ИНХ-ын дарга хурлын ирцийг бүртгэн оролцогчдоор гарын үсэг зуруулж, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу хөтөлж, ИНХ-ын Тэргүүлэгчдийн гарын үсгээр баталгаажуулна.

5.10. Баг, хорооны Засаг дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх энэ журмын 5.7-д заасан урьдчилсан жагсаалтад багтсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал нэг бүрийг ИНХ-д танилцуулна.

5.11. Баг, хорооны Засаг дарга ИНХ-д ОНХС-аас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар тайлагнахдаа энэ журмын 9.4, 9.5-д заасан этгээдийн хийсэн ажлын тайлан, тэмдэглэл, гаргасан дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг сонсгож болно.

5.12. Баг, хорооны ИНХ-ын дарга энэ журмын 5.10-д заасны дагуу танилцуулсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал болон тухайн хурлын үеэр дэвшүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал тус бүрийг дэмжиж буй эсэхийг ил тод санал хурааж шийдвэрлэнэ.

5.13. Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг энэ журмын 5.12-т заасан санал өгсөн иргэдийн тоог баг, хорооны сонгуулийн насны иргэдийн нийт тоонд харьцуулсан харьцаагаар эрэмбэлсэн тэргүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг ИНХ-ын тогтоолоор батална.

5.14. Баг, хорооны ИНХ-ын дарга энэ журмын 5.13-т заасан жагсаалтыг энэ журмын 6 дугаар хавсралтад заасан баг, хорооны ИНХ-ын тэмдэглэлд тусгана.

5.15. Баг, хорооны Засаг дарга энэ журмын 5.13-т заасан тогтоол болон энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийн танилцуулгыг энэ журмын 5.8-д заасан хугацаанд багтаан сум, дүүргийн Засаг даргад албан бичгээр хүргүүлнэ.

¹⁰ 3.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

¹¹ 6.3.4. Орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;

ын 3.1.7¹², “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.7¹³ дахь заалттай нийцээгүй байна. Үүнд:

Биндэр сумын гудамжны гэрэлтүүлэг 27.0 сая төгрөг, Хэрлэн сумын гэр хорооллын айл өрхийг эко нойлтой болгох 30.0 сая төгрөг, Хогны менежментийг боловсронгуй болгох ажлын хүрээнд хогны машиныг байрлал тогтоогчтой болгох 7.0 сая төгрөгийн ажлууд байна.

Аудитаар иргэдээс санал аваагүй, сумын чиг үүрэг болон журамд нийцээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Баянхутаг, Баянмөнх сумдын Засаг дарга нарт зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт нийцээгүй болон сумын хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын А/371 дүгээр захирамжаар ОНХС-аас санхүүжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Ажлын хэсэг 326 иргэдээр хэлэлцүүлгийг зохион байгуулж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс гаргасан ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх 52 төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг танилцуулж, хэлэлцүүлгийн явцад гарсан 8 саналыг нэмж, нийт 60 саналыг “их санал авсан” дарааллаар эрэмбэлсэн байна.

Ажлын хэсэг хэрэгжүүлэх боломжтой ажлын жагсаалтыг гаргаж дүгнэлт зөвлөмжийг бэлтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй байна. Энэ “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 7.7¹⁴ дахь заалтад нийцээгүй байна.

Аймгийн ОНХС-аас санхүүжүүлэхээр нийт 7,235.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 2,485.7 тэрбум төгрөгийн төсөвт зардлыг 2019 онд санхүүжүүлэхээр төлөвлөж, аймгийн ИТХ-аар баталсан байна.

Эдгээр арга хэмжээнээс 23 нь “Төсвийн тухай” хуулийн 58.2¹⁵, “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.1¹⁶, 4.2.3¹⁷-т заасан аймгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нийцэж байгаа бол 240.0 сая төгрөгийн 2 арга хэмжээ нийцээгүй байна. Үүнд:

Мөрөн сумын ногооны талбайг хаших 60.0 сая төгрөг, Хэрлэн сумын 2,3-р багт ахуй үйлчилгээний төвийн барилга барих 180.0 сая төгрөгийн ажлууд нийцээгүй байна.

Мөн хуулийн 58.4-т заасан сумын хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах аар ажлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

¹² 3.1.7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах;

¹³ 6.3.7. төслөөр шинээр бий болсон эсхүл сайжруулсан өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдолтой урсгал зардлын тооцоо, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгасан байх.

¹⁴ 7.7. Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

¹⁵ 58.2. Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

¹⁶ 4.2. ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно: 4.2.1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан зүйлс;

¹⁷ 4.2.3. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11-д зааснаас бусад төрлийн үйлчилгээний зардал;

Цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тохижуулахад Өмнөдэлгэр суманд 20.0 сая төгрөг, Баянмөнх суманд 40.0 сая төгрөг, Гурванбаян тосгонд 20.0 сая төгрөгийн ажил, Баян-Овоо сумын Гүрмийн нуурын хашаажуулах 80.0 сая төгрөгийн, Баян-Адрага сумын төвлөрсөн хогийн цэг байгуулж, ковш худалдан авахад 80.0 сая төгрөгийн ажлууд багтаж байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь төсөвт өртгийн хувьд тухайн сумаас хэрэгжүүлэх боломжтой ажлууд байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл бүрэн хийгдээгүй төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөж батлуулсан нь “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3¹⁸, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3¹⁹ дахь заалттай нийцээгүй байна. Тухайлбал:

Норовлин сумын инженерийн шугам сүлжээний ажил хийгдээгүй, Гүрмийн нуурыг хашаажуулах ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл шаардлага хангаагүй, мөн ажлыг зураг төсвийн дагуу хийгдээгүй нь ажлын гүйцэтгэл, чанар байдалд нөлөөлсөн байна.

Биндэр суманд Онон голын далан барих 8.6 сая төгрөгийн ажил, Баян-Адрага суманд хогийн цэгийг хаших 10.0 сая төгрөгийн ажлыг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажилтай давхардуулан төлөвлөсөн байна.

Аймгийн Төрийн аудитын газрын Иргэний танхимаас болон аудитын баг сум орон нутагт ажиллахдаа “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт” сэдвээр 1135 иргэнээс санал, асуулга авч, дүнг нэгтгэсэн. Санал асуулгад оролцогсдын 26.3 хувь нь 20-30 настай, 29.6 хувь нь 31-40 настай, 22.1 хувь нь 41-50 настай, 22.4 хувь нь 51-ээс дээш настай байна.

Санал асуулгад оролцогсдын 44.1 хувь нь ОНХС-ийн талаар хангалттай мэдээлэлтэй ба мэдээллийг Засаг дарга, багийн даргаас, 31.3 хувь нь орон нутгийн мэдээллийн хэрэгслээс, 27.4 хувь нь орон нутгийн мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр, иргэний танхимаар, 3.5 хувь нь нутгийн иргэдээс 37.7 хувь нь авдаг байна.

ОНХС-ийн талаарх хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн эсэх асуулгад 27.2 хувь нь тодорхой хэмжээнд судалсан, 72.8 хувь нь судлаагүй гэж хариулжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудыг багийн Засаг дарга иргэдэд танилцуулах, нээлттэй хэлэлцүүлэг “хийсэн” эсэхэд санал асуулгад оролцогчдын 56.9 хувь нь “сайн мэдэхгүй” гэж хариулсан, сумын Засаг дарга иргэдээс авсан саналыг эрэмбэлж, хамгийн их авсан ажлуудыг иргэдэд танилцуулах нээлттэй хэлэлцүүлэг “хийсэн” эсэхэд санал асуулгад оролцогсдын 47.4% нь “сайн мэдэхгүй” гэж хариулсан нь ОНХС-аас санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тодорхойлох ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодиттой хэрэгжиж байгаад хяналт тавьдаг эсэхэд санал асуулгад оролцогчдын 33.8 хувь нь хяналт тавьдаг, хийгдсэн бүтээн байгуулалтад сэтгэл хангалуун байгаа эсэх асуулгад 48.5 хувь нь тийм гэж хариулсан байна.

¹⁸ 3.1.3.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

¹⁹ 6.3.3. хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;

Иргэдээс авсан санал асуулгаас үзэхэд ОНХС-ийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, идэвх оролцоо муу, мөн аймаг, сумын ЗДТГ-аас ОНХС-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийт, иргэдэд хүргэх ажил хангалтгүй байна.

2.2 АЙМАГ, СУМЫН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.2.1. Ихэнх тендерийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс хугацаа хоцроож зарласан байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт 196 төсөл, арга хэмжээний 6 нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж, 5,033.2 сая төгрөгийн 190 арга хэмжээнээс “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1,132.7 сая төгрөгийн 9 арга хэмжээг, харьцуулалтын аргаар 2,466.6 сая төгрөгийн 81 төсөл арга хэмжээг, шууд худалдан авалтын аргаар 460.5 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээг, 130.5 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж, 749.4 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээний худалдан авалтыг хэрэгжүүлээгүй байна. / Хавсралт 2/

ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тоон мэдээлэл

/тоогоор/

Төлөвлөсөн ажил		Нээлттэй тендер шалгаруулалт	Худалдан авах ажиллагааны онцгой журам			ОНОХА
Өмнөх оноос шилжсэн	Шинэ оны ажил		Хязгаар - лагдмал ТШ	Харьцуулалтын арга	Шууд гэрээ байгуулах	
6	190	9	0	81	65	17

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 27 төсөл, арга хэмжээнээс цахимаар 1,008.7 сая төгрөгийн 7 арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын, 855.8 сая төгрөгийн 18 арга хэмжээг харьцуулалтын аргаар, 20.0 сая төгрөгийн 2 худалдан авалтыг шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг 39.2 сая төгрөгийн хэмнэлттэй зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-аас хэрэгжүүлэх 150.0 сая төгрөгийн Норовлин сумын шугам сүлжээ тавих ажлын зураг төсөв хангалтгүйгээс тендер зарлаагүй, 270.0 сая төгрөгийн Хэрлэн сумын 1-р багийн халаалтын зуухны барилга барих ажилд гүйцэтгэхээр шалгарсан “Агнитрейд” ХХК гэрээ байгуулаагүй, 142.0 сая төгрөгөөр Чингис хотын 42 цэгт камер суурилуулах ажлын тендерийг дахин зарлахаар болсон байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг баталсан боловч төсөл арга хэмжээ зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй батлагдсанаас шалтгаалан тендерийг батлагдсан төлөвлөгөөнөөс 5-100 хоногоор 15 ажил, 101-200 хоногоор 10 ажил, 258 хоногоор 1 ажлыг хугацаа хоцроон зарласан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 166 төсөл арга хэмжээнээс 6 төсөл арга хэмжээ өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж, тайлант онд хэрэгжүүлсэн 146 арга хэмжээнээс 124.0 сая төгрөгийн 2 арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын, 1,610.8 сая төгрөгийн 63 арга хэмжээг харьцуулалтын аргаар, 571.0 сая төгрөгийн 80 худалдан авалтыг шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг 54.3 сая төгрөгөөр хэмнэлттэй зохион байгуулсан байна. Сумд чиг үүрэгт нийцээгүй 187.4 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээнд худалдан авалтыг зохион байгуулаагүй байна.

Баянхутаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 3 арга хэмжээг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч тендерийн хорооны хурлын тэмдэглэлд гарын үсэггүй, ашиг сонирхлын зөрчилгүй болон үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдэгдэл, Засаг даргад хүргүүлсэн зөвлөмж байхгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу, архивын нэгж болгон үдээгүй зөрчилтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49.1²⁰ дэх заалтад нийцээгүй байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгийн 0.06 хувийг чиг үүрэгт нийцээгүй төсөл арга хэмжээнд зарцуулжээ.

Хэнтий аймгийн хэмжээнд 2019 онд нийт 181 төсөл, арга хэмжээнд 4,782.9 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсний дотор суурь зарлагын 3 арга хэмжээний 606.5 сая төгрөг, 2018 онд эхэлсэн 37.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ байна. Батлагдсан 199 төсөл, арга хэмжээнээс 749.4 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2019 онд хэрэгжүүлэх 178 төсөл, арга хэмжээнд нь 4,231.9 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулагдаж, нийт 4,176.4 сая төгрөг зарцуулжээ.

- ❖ Бүрэн хэрэгжсэн 169 төсөл, арга хэмжээнд гэрээний дагуу 4,026.8 сая төгрөг зарцуулж, 1 арга хэмжээнд 8.0 сая төгрөг олгогдоогүй дутуу байна.
- ❖ Дутуу хэрэгжсэн 9 төсөл, арга хэмжээнд 159.0 сая төгрөг зарцуулж, 31.5 сая төгрөгийн ажлыг 2020 онд гүйцэтгүүлэхээр болжээ.

Аудитын явцад дараах зөрчил илэрсэн нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.5²¹ дахь заалтад нийцээгүй байна. Үүнд:

- ❖ Өмнөдэлгэр сумын Наран багт соёлын төв барих ажлыг дуусаагүй байхад дутуу 11.0 сая төгрөгийн санхүүжилтийг барьцааны дансанд шилжүүлсэн.
- ❖ Хэрлэн сумын эко нойлтой болох 30.0 сая төгрөгийн ажил бүрэн хэрэгжээгүй боловч гэрээнд тусгасны дагуу банкны баталгаа гаргуулан дутуу 30.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон.
- ❖ Бор-Өндөр сумын ОНХС-аас мөсөн гулгалтын талбай байгуулах тайлант онд хэрэгжээгүй ажилд 10.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон.
- ❖ Биндэр сумын ОНХС-аас 1,2,4-р багуудад хийгдэх мал угаалгын ванн хийх ажлын явцад хяналт тавиагүй, огт хийгдээгүй ажилд нийт 6.6 сая төгрөгийг олгосон байна.
- ❖ Норовлин сум хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хийгээгүй, хүлээн авсан комиссын актгүй, соёлын төвийн тоног төхөөрөмжийг худалдан авах гэрээ байгуулахгүйгээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хэрлэн сумын гэр хорооллын айл өрхийг эко бие засах газартай болгох / төвийн 5-н багт / ажлыг ИТХ-аар баталсан боловч зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, газрын асуудлыг шийдээгүйгээс хэрэгжих боломжгүй болсон учир зураг төсвийг шинээр хийж 5-р багт байрлах цэцэрлэгт хүрээлэнд нийтийн бие засах газрыг байгуулжээ. Энэ нь Сангийн сайдын 2016 оны “Журам шинэчлэн батлах тухай” 415 дугаар тушаалын хавсралтаар

²⁰ “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.”

²¹ Сангийн сайдын 2016 оны “Журам шинэчлэн батлах тухай” 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно

батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.21²² дэх заалтыг зөрчсөн байна.

Дээрх зөрчлөөс 6.6 сая төгрөгийн хөрөнгийг төлүүлэх 1 төлбөрийн акт тогтоож, 30.0 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 1 албан шаардлага болон зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг төрийн байгууллагын данс бүртгэлд авах ажлыг зохион байгуулж байгаа боловч урсгал зардлыг тооцоогүйгээс ашиглалт, хадгалалт, хамгаалалтын асуудалд хүндрэл үүсэж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр тайлант хугацаанд бүрэн болон он дамжиж хэрэгжиж буй 178 төсөл, арга хэмжээнд 4,176.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Эдгээр хөрөнгийг дараах салбар чиглэлээр ангилан авч үзвэл орон нутгийн тохижилт, үйлчилгээ бүтээн байгуулалтад чиглэсэн 112 арга хэмжээг 3,217.9 сая төгрөг, Боловсролын салбарт чиглэсэн 16 арга хэмжээг 218.7 сая төгрөг, Соёлын салбар чиглэсэн 11 арга хэмжээг 168.5 сая төгрөг, Эрүүл мэндийн салбарт чиглэсэн 7 арга хэмжээг 151.7 сая төгрөг, ХАА-ын салбарт чиглэсэн 10 арга хэмжээг 142.0 сая төгрөг, Усжуулах, усан хангамжийн чиглэлд 22 арга хэмжээг 277.5 сая төгрөгөөр тус тус хэрэгжүүлсэн байна.

ОНХС-аас бэлтгэсэн хөрөнгийг бүртгэсэн байдал

Д/д	Салбар, чиглэл	Хэрэгжүүлсэн		Хөрөнгөд бүртгэсэн		Бүртгэх боломжгүй	
		ТАХ-ний тоо	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	ТАХ-ний тоо	дүн /сая төгрөг/	ТАХ-ний тоо	дүн /сая төгрөг/
1	Орон нутаг	112	3217.9	102	2984.5	11	236.4
2	Боловсрол	16	218.7	15	194.5	1	24.2
3	Соёл	11	168.5	10	108.5	1	60.0
4	Эрүүл мэнд	7	151.7	7	151.7		
5	ХАА	10	142	7	135.4	3	6.6
6	Худаг ус	22	277.5	20	273.5	1	1.0
	Нийт дүн	178	4176.3	161	3848.1	17	328.2

Дээрх арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгасан эсэхийг үзэхэд 161 төсөл, арга хэмжээнд хамаарах 3,848.1 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд бүртгэж, 17 төсөл арга хэмжээнд хамрагдах 328.2 сая төгрөгийг хөрөнгийн дансанд бүртгэх боломжгүй, бараа материалын дансанд бүртгэсэн болон шууд зарлагдсан хөрөнгүүд байна.

Үүнээс оны эцэст аймгийн ОНХС-аар хэрэгжүүлээд бүртгэгдээгүй байсан 714.0 сая төгрөгийн 7 хөрөнгийг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулсан байна.

2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалтын байдалтай танилцахад дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

1. Мөрөн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн 9.4 сая төгрөгийн болон өмнөх онуудад хийгдсэн гудамжны гэрэлтүүлгүүдийг 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий төв зам, гэрэлтүүлэг хийгдэхтэй холбоотойгоор буцаан авч буулгасан байна. Энэ нь ОНХС болон хөрөнгө

²² “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэх тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно”

- оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг үндэслэлтэй хийгээгүй, уялдаа холбоогүй байгаатай холбоотой байна.
2. Баянхутаг сумын Эрүүл мэндийн төвийн дээврийн засварыг 20.0 сая төгрөгөөр Хээнцэр тохилог хийц ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн боловч 1 сарын дараа салхинд хуурч ойчсон байна. 2020 оны 5 сард бороо гоожсон учир уг компани дээврийг дан хар цаасаар бүрж, хар лав зарим газарт цутган, 2020 онд дахин нэг үе хар цаасаар бүрэхээр тохирсон байна. Эндээс харахад хийсэн ажлын чанар байдалд хяналт тавьж, төсөвт өртгийг бодитой төлөвлөх шаардлагатай байна.
 3. Хэрлэн сумын 5-н багт цэцэрлэгт хүрээлэнд нийтийн бие засах газрыг огт ашиглаагүй, Булаг багт байгуулсан гүний худаг мөн ашиглалтгүй, цонх хагарсан байдалтай, хогийн менежмент сайжруулах зорилгоор Хот тохижилтын хог ачих машинуудад хяналтын GPS-ийн төхөөрөмж суурилуулсан бөгөөд тус төхөөрөмжийг 2020 оны 3-р сараас хойш ашиглаагүй хяналт тавиагүй, ашиглалт хангалтгүй байна.
 4. Бэрх хотыг камержуулах ажлыг өмнөх онуудад хийгдсэн ажлууд дээр нэмж 8.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийсэн боловч Цагдаагийн тасгийн албан хаагчдын ашиглалт байхгүй, камерууд ажиллахгүй байна. Мөн 52.1 сая төгрөгөөр хэрэгжсэн наадмын талбайн барилгад айл өрхүүд үхэр хашиж малын хашаа болгон ашиглаж байна.
 5. Баян-Адарга сум 2019 онд хуучин хогийн цэгийг төмөр тороор хашаажуулсан 10.0 сая төгрөг ажил хийсэн боловч мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хогийн цэгийн дэргэд шинэ хогийн цэг байгуулж хуучин хогийн цэгийг ашиглахгүй болсон байна. Шинэ хогийн цэг нь нийт 80.0 сая төгрөгийн өртөгтэй үүнээс ковш авахад 50.0 сая төгрөг, үлдсэн 30.0 сая төгрөгийг талбай бэлдэхэд зарцуулан, хуучин хогийн цэгийг дарж булшлахын оронд хашаажуулсан мөн хогийн цэгийн дэргэд шинэ хогийн цэг байгуулсан зэрэг үр дүнгүй хөрөнгө зарсан байна.
 6. Баян-Адрага сумын ОНХС-аас 6.4 сая төгрөгөөр бэлтгэсэн арьс шир элдэх тоног төхөөрөмжийн зарим эд ангиуд тоногдсон, эвдэрсэн, хадгалалт хамгаалалт хангалтгүй, хөрөнгөд тавих хяналт сул байна.
 7. Баян-Адрага сумын төвийн худагт автомат төхөөрөмж суурилуулах 8.0 сая төгрөгөөр автоматжуулалт хийгдсэн боловч хөрөнгөнд тавих хяналт сул ашиглалтын буруугаас хөлдөөж, ажиллахгүй болсон байна.

Аудитаар 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.12²³ дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй дээрх зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх албан шаардлагуудыг холбогдох сумын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэн бий болсон арга хэмжээнүүд нь аймаг, сумын хөгжилд өнгө үзэмж нэмэн, тохижилт, соёлжилтыг бий болгож байгаа боловч зарим талаар төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө бэлтгэснээс хүндрэлтэй асуудлууд гарч байгаа нь ОНХС-ийн хөрөнгийн үр нөлөөг бууруулахад хүргэж байна. Тухайлбал:

Өмнөх онуудад халуун усны барилга, ахуй үйлчилгээний барилга, мал нядалгааны цэг, арьс шир элдэх тоног төхөөрөмж зэрэг хөрөнгүүдийг бэлтгэсэн нь урсгал зардал, ажиллах хүчний асуудал шийдээгүйгээс бүрэн ашигладаггүй, орон нутгийн өмчийн барилга байгууламжид гэрээ байгуулан ажилласан иргэд үйл ажиллагаа жигдрээгүй, ашиггүй ажилласан зэрэг шалтгаанаар түрээсийн төлбөр төлдөггүй, уг хөрөнгүүдийн эвдрэл гэмтэлд засвар үйлчилгээ хийдэггүй, хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.

²³ “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.”

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВЬДАГҮЙ, ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.**3.1 ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦАД АЙМАГ, СУМЫН ЗДТГ-УУД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.****3.1.1. Аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороонууд 2019 онд ОНХС-аас санхүүжүүлсэн нийт хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 73.5%-д хяналт шалгалт хийсэн байна.**

Аймгийн ИТХ-аас 2019 оны 162 дугаар албан бичгээр сумдын ИТХ-ын дарга нарт хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа арга хэмжээний тендер сонгон шалгаруулалт, хугацаа, хэрэгжилтийн чанар байдалд хяналт, шалгалт хийж ажиллах тухай албан бичгийг хүргүүлж ажилласан байна.

Дээрх үүрэг чиглэлийн дагуу сумын ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн нийт 151 хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 73.5 хувьд 12 сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцын хяналт хийж тайлагнасан байна.

Бэрх, Гурванбаян, Хэрлэнбаян-Улаан тосгоны ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хийгдээгүй, Баянхутаг, Биндэр, Норовлин, Бор-Өндөр, Хэрлэн сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооноос хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ-аас аймгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээний тендер сонгон шалгаруулалт, ажлын явц, хяналтын асуудлаар хэлэлцэн үүрэг чиглэл өгч ажилласан гэсэн боловч аймаг, сумын ИТХ нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4²⁴ дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Тогтвортой амьжиргаа төсөл 3 -ийн орон нутаг дахь чадавхжуулах багаас 2020 онд 6 суманд ажиллаж ОНХС-ийн үйл ажиллагааны 2019 оны хэрэгжилтийн үр дүнг танилцуулж, сангийн үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлэх зөвлөмж өгч, ОНХС-ийн шинэ удирдлагын мэдээллийн санд мэдээлэл оруулах талаар зааварчилгаа өгсөн байна.

3.1.2. Аймаг, сумын захиргааны байгууллагууд ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийгээгүй байна.

Харин аймгийн ЗДТГ-т аймаг, сумын түвшинд “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилт болон төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагнал, үр дүнд хийсэн мэдээ тайлан байхгүй, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5²⁵ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

²⁴ 9.4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

²⁵ 9.5. “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ.”, 9.6. “Энэ журмын 9.5-д

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба сумдын ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийж, нэгдсэн тайлан гаргасан байна. Илэрсэн зөрчил дутагдлыг засаж залруулах 5 зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт өгч ажилласан байна.

Сумын ЗДТГ-аас ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн нийт 151 хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 83.4 хувьд нь явцын хяналт тавьж баталгаажуулсан байна.

3.2. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХОЛБОГДОХ ЖУРАМ, ЗААВРЫН ДАГУУ САНГИЙН ЯАМАНД ХҮРГҮҮЛЭЭГҮЙ, НЭГДСЭН МЭДЭЭ ТАЙЛАНГ ГАРГААГҮЙ БАЙНА.

3.2.1. Зарим сумын ЗДТГ ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан хугацаанд аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэст ирүүлээгүй, аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэс тайлан мэдээг гаргаж СЯ-д хүргүүлээгүй, нэгдсэн мэдээ тайланг гаргаагүй байна.

Өмнөх аудитын зөвлөмжийн дагуу аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэс “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 31-ний 9/207 дугаар албан бичгээр нэгдсэн тайлангийн өгөгдлийн дагуу мэдээлэл цуглуулах маягыг сумын Засаг дарга, тосгоны захирагч нарт хүргүүлсэн боловч тайлан, мэдээллийг 13 сум, 2 тосгоноос ирүүлж, Батширээт, Баян-Адрага, Дархан, Дэлгэрхаан, Хэрлэн сумын ЗДТГ-ын дарга нар, Хурх, Хэрлэнбаян-Улаан тосгоны ЗАА-ны дарга нар ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй, ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.2²⁶ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9²⁷ дэх заалтын дагуу тайланг хүргүүлэхээр заасан байна.

заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ.”

²⁶ 9.2 “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаах

²⁷ 9.9 “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;

9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;

9.9.3.ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;

9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн фото зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;

9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;

9.9.6.ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;

9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга;”

Аймгийн ХОХБТ-ийн хэлтэс “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3²⁸, 9.9²⁹ дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй, ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг гаргаж Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

3.2.2. 2019 оны сүүлийн улиралд хийгдсэн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага бүрэн хэрэгжиж, зөвлөмжийн хэрэгжилт 71.8 хувьтай байна.

ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар 20.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, аймаг, сумын Засаг дарга нарт сангийн хөрөнгийн үр ашигтай, үр нөлөөтэй арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулах талаар 84.9 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

Мөн аймаг, сумын Засаг дарга нарт 5 зөвлөмж, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 1 зөвлөмжийг тус тус хүргүүлэн ажиллажээ.

Аудитын дүн, хийсэн судалгаанаас үзэхэд өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актын биелэлт 100 хувь, өгсөн албан шаардлагын биелэлт 100 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 71.8 хувьтай байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

1. Аймаг, сумын ОНХС-аас санхүүжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журмуудыг баримтлах, ажлын хэсгийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах-77%;
2. ОНХС-аас санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь нийтийн эрх ашигт нийцсэн, орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт байхаар төлөвлөх-97,8%;
3. Нарийн мэргэжил шаардагдахгүй, 20.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөгтэй ажил, үйлчилгээг “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу зохион байгуулах-100%;
4. Аймаг, сумын ОНХС-аас санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг холбогдох журмуудын дагуу зохион байгуулах-73.8 %;
5. Аймаг, сумын ОНХС-аас санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тус бүрээр нь гарган, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн дүгнэлт өгч, гарсан алдаа дутагдлыг засаж залруулах шаардлагатай арга хэмжээг авч ажиллах-0%;
6. Аймаг, сумын ОНХС-аас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлд тавих хяналтыг тогтмол зохион байгуулж, гарч буй алдаа дутагдлыг тухай бүр засуулах арга хэмжээг авч, хэрэгжүүлж байх 100 % -тай байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийн хувьтай харьцуулахад биелэлтийн хувь өссөн үзүүлэлттэй боловч 1 зөвлөмжийг огт хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар ОНХС-ийн төсвийн гүйцэтгэл болон хэрэгжилтийн тайланг гаргаж Сангийн яаманд хүргүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн ЗДТГ-г хүргүүлэхээр шийдвэрлэв.

²⁸ 9.3.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

²⁹ 9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

Аудитаар иргэдээс санал аваагүй, ОНХС-ийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлээгүй, төсөл арга хэмжээг чанаргүй хэрэгжүүлсэн, бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт хангалтгүй, мэдээ тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлээгүй зэрэг нийт 1,231.8 сая төгрөгийн 63 зөрчил дутагдал илрүүлж, 6.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 339.0 сая төгрөгийн илэрсэн зөрчлийг арилгуулах, дахин давтахгүй байх 8 албан шаардлага, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлж, нэгдсэн тайлангаар 4 зөвлөмж өгч ажиллалаа.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Аймаг сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилаагүй байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх суурь зардлыг тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан хэмжээг нэмэгдүүлэн баталсан байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр цаашид гарах зардал болон төсөвт нөлөөлөх нөлөөллийг тооцоогүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
4. Аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний нэгдсэн тайлан, мэдээг гаргаж, үр дүнг тооцоогүй байна.
5. Аймаг, сумын ЗДТГ-ууд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймаг, сумын Засаг дарга нарт

1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөж батлахдаа холбогдох хууль, журмуудыг бүрэн мөрдөж ажиллах.
2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журмын дагуу төлөвлөлтийн шаардлагыг хангасан, нийтийн эрх ашигт нийцсэн байдлаар төлөвлөх.
3. Аймаг, сумын ИТХ, ЗДТГ-аас ОНХС-аас санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагналын явцад тавих хяналтыг холбогдох журмуудын дагуу зохион байгуулах
4. Тайлант он болон өмнөх онуудад ОНХС-аас санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, илэрсэн алдаа дутагдлыг засаж залруулах арга хэмжээг авч ажиллах.

Аудитын тайланд дурдсан зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр хийгдсэн ажил, үр дүнгийн мэдээллийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Ирүүлсэн албан бичиг	Тайлбар
 <p>ХЭНТИЙ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</p> <p>23119 Чангас хот, Хэнтий аймаг, Утас/факс: 70-56-24-12 E-mail: info@zdtg@khentii.gov.mn</p> <p>2020.11.16 № 9/2334 тантай _____-ны № _____-т</p> <p>ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>"Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын асуудлын бүртгэл, тайлангийн төсөлтэй танилцаад саналаа хавсралтаар хүргүүлж байна. Хавсралт 1 хуудастай.</p> <p>ДАРГА  Ж.ГАНБААТАР</p> <p>231072431</p>	<p>Тайлангийн төсөлтэй танилцаад ирүүлсэн саналыг авч үзэхэд:</p> <p>1. "Мөрөн сумын ногооны талбайн хашаа", "Хэрлэн сумын багуудад /2,3 баг/ ахуй үйлчилгээний барилга" барих ажлууд нь Төсвийн тухай хуулийн 58.2.3, 58.2.6 дахь заалтад нийцсэн ч ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.2.1 дахь заалт буюу "Төсвийн тухай хуулийн 60.3.4 дахь заалтад нийцэхгүй, мөн Төсвийн тухай хуулийн 58.2.15-д хамаарахгүй гэж үзсэн тул тайланд өөрчлөлт ороогүй.</p>

<p style="text-align: right;">9/2019 тоотын хавсралт</p> <p style="text-align: center;">Аудитын тайлангийн төсөлд санал</p> <p>ОНХС-ийн үйл ажиллагааны журмын Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан. Энэ нь тус журмын 7.7-д заасан хугацааг баримталж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх боломжгүй нөхцөл үүссэн.</p> <p>"Мөрөн сумын ногооны талбайн хашаа", "Хэрлэн сумын багуудад ахуйн үйлчилгээний төвийн барилга /2.3-р баг/ төсөл арга хэмжээнүүд нь төсвийн тухай хуулийн 58.2.3, 58.2.6, 58.2.15 зэвсгүүдэд нийцж байна</p> <p>Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажилтай давхцуулан төлөвлөсөн асуудлыг Бичдэр, Баян-Адарга сумын Засаг даргад аудитын зөвлөмж хүргүүлэх нь зүйтэй.</p> <p>Сумдын тайлагналт хангалтгүй байгаагаас хэрэгжилтийн тайланг ирүүлэх хугацаа завч албан бичгээр сумдад хүргүүлсэн ч бүрэн ирүүлээгүй тайлагналт хангалтгүйгээс хэрэгжилтийн тайлангийн нэгтгэл хийгдэх боломжгүй нөхцөл үүссэн. Иймээс сумдад журмын 9.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлэх саналтай байна.</p> <p>"Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоолоор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс байгуулагдсан.</p> <p>Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны ХЭГ/1433 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн чиг үүргийн талаар чиглэл ирүүлсэн ба түүнд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь аймгийн хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг ерөнхий арга зүйгээр хангах бөгөөд цаашид Засгийн газрын болон Засаг даргын шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг тодорхойлсон.</p> <p>Сангийн сайдын 2016 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.5-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийхээр тусгасан ч тухайлан аймгийн Засаг даргын Тамгын газар, ХШУДАХэлтэс гүйцэтгэнэ гэж заагаагүй.</p> <p>Дээрх журмын 9.6-д "энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хүлээнэ" гэж тусгасан ба ОНХС-аас 2019 онд санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалт хийх үүрэг хүлээгээгүй болно.</p>	<p>2. Аудитын явцад сумдад ажиллан илэрсэн зөрчлийг танилцуулан, зөвлөмжийг өгч, нэгдсэн тайлангаар акт, албан шаардлагыг хүргүүлсэн. Тайланг хүлээн авч нэгтгэн тайлагнах, тайлан ирүүлээгүй сумдын ажилтнуудад хариуцлага тооцох нь АЗДТГ-ын эрх үүрэг болно.</p> <p>3. АЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс ОНХС-ийн төсөл, арга хэмжээний хүрээнд санхүүгийн болон гүйцэтгэлийн хяналт, шалгалт хийх үүрэг хүлээгээгүй гэсэн саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.</p>
--	--

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2020 оны 11 дугаар сарын 13

Дугаар А/29

Чингис хот

**Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан "Нийслэл, аймаг дахь Төрийн аудитын газруудын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн удирдамжаар хийгдэж буй "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Нийцлийн аудитын тайлангаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Санхүүгийн хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.
4. Нийцлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийцлийн аудитын багийн ахлах аудитор /Н.Туяа/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

023010100